# ХӨВСГӨЛ АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН ЗАХИРГАА,ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| **_Нэг. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт._** | | | | | | | |
| Нийгмийн даатгалын талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг хангуулах, нийгмийн даатгалын төв, орон нутгийн нэгжийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын дунд хугацааны төсвийн төсөл, төсөөлөл болон төсвийн нарийвчилсан хуваарийн санал боловсруулах, гүйцэтгэлд хяналт тавих, судалгаа хийх, ирээдүйн төлөв байдал, урт хугацааны урьдчилсан тооцоолол хийх, үнэлэлт дүгнэлт өгөх, санал боловсруулах | | | | | | | |
| 1.1.1. | Нийгмийн даатгалын багц хууль /шинэчилсэн найруулга/-ийг хэрэгжүүлэхтэй холбоотой шинээр батлагдсан дүрэм, журам, дээд газраас ирүүлсэн заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтийг зохион байгуулах. | Шаард-лагагүй | Хэрэгжүүлсэн дүрэм, журам, заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн тоо | Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой НДЕГ-аас 2023 онд ирүүлсэн 12 удаагийн зөвлөмжийн хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан. | Дээд газраас ирүүлсэн дүрэм, журам, заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж, үр дүнг тооцож ажилласан байна. | Нийгмийн даатгалын багц хууль /шинэчилсэн найруулга/-ийг хэрэгжүүлэхтэй холбоотой шинээр батлагдсан дүрэм журам, тушаал, заавар, чиглэл, зөвлөмжийн хэрэгжилтийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс зохион байгуулж ажиллалаа. Дээд газраас хүргүүлсэн журам заавар, чиглэл, зөвлөмжийг хэрэгжүүлэх асуудлаар газрын болон сумдын байцаагч нарт танхимаар 3, цахимаар 8, нийт 11 удаагийн сургалт хийж, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллалаа. Тайлант хугацаанд нийт 79 дүрэм, журам, заавар, зөвлөмж, чиглэл, албан бичгийн хэрэгжилтийг зохион байгуулж, үр дүнг тооцон ажилласан байна. Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн "Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай" 120 дугаар тогтоолын дагуу 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 22654 тэтгэвэр авагчийн тэтгэврийг 100.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулж хэрэгжүүлсэн. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| ***Гурав. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт*** | | | | | | | |
| Нийгмийн даатгалын бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, сангийн болон үйл ажиллагааны зардлын зарцуулалтад аудит хийх, дүгнэлт зөвлөмж гаргах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх | | | | | | | |
| 3.1.1. | Байгууллагын нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтэд хяналт тавих; | - | Нийтийн ил тод мэдээллийн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-8.6 дугаар заалтын дагуу 48 мэдээллийг вебсайт хуусанд бүрэн, үнэн, зөв байршуулан ажлын тайланг ДАМГ-т 2024 оны 07 дугаар сарын 09, 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор хүргүүлнэ. | Байгууллагын нээлттэй мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу 48 мэдээллийг 2023 оны байдлаар 59.5 хувьтай байршуулсан. | Байгууллагын нээлттэй мэдээллийг ил тод болгож, иргэдийн мэдээлэл хайх, хүлээж авах эрхийг хангасан байна. | Байгууллагын нээлттэй мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу :<br>8.2.9 дэх заалт сарын мэдээ, статистик мэдээ<br>8.4.1 дэх заалт Өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөв, дараа оны төсвиййн төсөл<br>8.4.2-8.4.9 дэх заалтын мэдээллийг бэлтгэн хугацаанд нь вебсайтад байршуулсан мэдээлэлд хяналт тавьж ажилласан.<br>https://huvsgul.ndaatgal.mn/ вэб сайтад “Нээлттэй өгөгдөл байршуулах төлөвлөгөө, хуваарь батлах тухай” А/20 дугаар тушаалын гуравдугаар хавсралтад заасан жагсаалтын дагуу нээлттэй мэдээллийг цахим хуудсанд, дөрөвдүгээр хавсралтад заасан жагсаалтын дагуу нээлттэй мэдээллийг мэдээллийн самбарт байршуулах, хэрэгжүүлэх ажлын хүрээнд мэдээллүүдээ shilen.gov.mn вэб сайтад 5 төрлийн 87 үзүүлэлтээр байршуулан ажиллаж байна. Үүнд: Хууль эрх зүй, даатгалын цахим үйлчилгээ, НД-ын үйлчилгээний төрөл, байгууллагын санхүүгийн статистик мэдээ, цаг үеийн мэдээ мэдээлэл, үйл ажиллагааны ил тод байдал, хүний нөөцийн ил тод байдал, байгууллагын төсвийн орлого, зарлагын шилэн дансны мэдээллийг харах боломжтой.<br>https://shilen.gov.mn/index -д нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээгээр 2024 оны жилийн эцсийн байдлаар 88,5%-тай үнэлэгдсэн байна.<br>Мөн shilen.gov.mn-д байршуулах нээлттэй мэдээллийг жилийн эцсийн байдлаар 100 хувь бүрэн байршуулж, | 89% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хянасан төлөвтэй байна. | |
| 3.1.2. | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих; | - | Нийгмийн даатгалын байгууллагын сан, үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг хагас жилийн байдлаар 85 мэдээллийг 07 дугаар сарын 09-ны өдрийн дотор, жилийн эцсийн байдлаар 167 мэдээллийг Shilendans.gov.mn цахим хуудсанд байршуулан ДАМГ-т 2024 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор хүргүүлнэ. | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, 342 мэдээллийг хяналт тавьсан. 2023 оны байдлаар 95.7 хувьтай хугацаандаа мэдээлэл байршсан. | Нийгмийн даатгалын байгууллагын санхүү болон сангийн мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн байршуулж, иргэдийг үнэн, зөв мэдээллээр хангасан байна. | Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үйл ажиллагааны 317425.6 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ, 1585536.0 мянган төгрөгийн орлогын гүйлгээ, нийгмийн даатгалын сангийн орлогын гүйлгээний 91330899.1 мянган төгрөгийн мэдээлэл, 99290844.9 мянган төгрөгийн зарлагын гүйлгээний мэдээлэлд,<br>Мөн хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэлд 1325.0 мянган төгрөгийн мэдээлэл, төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын мэдээлэлд үйл ажиллагаа 1585536.0 мянган төгрөг, нийгмийн даатгалын сангийн орлого 51030881.5 мянган төгрөг, зарлагын төсөв 197743711.7 мянган төгрөгийн зарлагын мэдээллийг байршуулсанд хяналт тавьж ажилласан байна. | 95% |
| Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг ажил олгогч, даатгуулагч, иргэн болон нийгмийн даатгалын орон нутгийн нэгжид хяналт шалгалт хийж шийдвэр гаргах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх, үр дүнг сайжруулах чиглэлээр санал боловсруулах | | | | | | | |
| 3.2.1. | Нийгмийн даатгалын тухай хуулийн хэрэгжилтийг дээд газраас өгсөн чиглэлийн дагуу болон хэлтсийн даргын баталсан удирдамжийн дагуу аж ахуйн нэгж, байгууллага болон дотоодын хяналт шалгалтын ажлыг зохион байгуулах. | Шаард-лагагүй | Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилтийг шалгаж, илэрсэн төлбөр, зөрчлийн 70.0 аас доошгүй хувийг барагдуулж ажиллана. | Илэрсэн төлбөр зөрчлийн 53,6 хувийг барагдуулж ажилласан. | Шалгалтын үр дүнг тухай бүрд нь тооцон, хэлтсийн даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж холбогдох шийдвэр гаргуулан актаар тогтоогдсон төлбөрийн 70-аас доошгүй хувийг барагдуулсан байна. | Газрын хяналт шалгалтын төлөвлөгөө, удирдамжийн дагуу 2024 онд Алаг-Эрдэнэ-38, Арбулаг-48, Баянзүрх-38, Галт-44, Рэнчинлхүмбэ-47, Тариалан-69, Түнэл-33, Тосонцэнгэл-53, Төмөрбулаг-34, Хатгал-40, Улаан-Уул-41, Цагааннуур-19, Их-Уул-46, Чандмань-Өндөр-49, Шинэ-Идэр-36, Эрдэнэбулган-32, Бүрэнтогтох-51, Цагаан-Үүр-26, Мөрөн-475, нийт 19 сумын 2023 онд тогтоогдсон 1219 тэтгэврийн тогтоолт, олголтыг цахим мэдээллийн сан болон үндсэн баримттай тулган шалгасан. Шалгалтаар 128 тэтгэвэрт баримт | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | материал дутуу бүрдүүлсэн зөрчил илэрснийг шийдвэрлэж ажилласан. Хяналт шалгалтын хугацаанд 3 сумын байцаагчид улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлсэн. Мөн 2024 онд шинээр тогтоогдсон тэтгэвэр 493, өөрчилсөн тэтгэвэр 121, ЖАТ-606, ХЧТАТ-349, Ажилгүйдлийн тэтгэмж-120, Оршуулгын тэтгэмж 133, ХЧАХХТА-ын сунгалт 503, нийт 2325 тэтгэвэр, тэтгэмжийн баримт материалын үндэслэлд хяналт тавьж, холбогдох хэлтэст шилжүүлсэн. Дотоодын хяналт шалгалтаар нийт 17 тэтгэвэр авагчтай холбоотой 26646.1 мянган төгрөгийн зөрчилд улсын байцаагчийн акт тогтоож 13638.7 мянган төгрөгийг барагдуулж, актын биелэлт 100.0 хувьтай байна. Тэтгэмжийн зарцуулалтад хийгдсэн дотоодын хяналт шалгалтаар 36 тэтгэмж авагчтай холбоотой 31889.2 мянган төгрөгийн зөрчил илэрч 13891.3 мянган төгрөгийг барагдуулж, актын биелэлт 43.5 хувьтай байна. 2023 онд зогсоогдсон 1021 тэтгэврийн хувийн хэргийг шалгаж газрын архивт шилжүүлсэн. Үүнээс: ӨН-485, ТА-117, ТД-419.<br><br>Хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу шимтгэлийн авлага өндөртэй болон төлөвлөгөөнд тусгагдсан 185 аж ахуйн нэгж байгууллагад төлөвлөгөөт хяналт шалгалтыг газрын даргын баталсан удирдамжийн дагуу хийж гүйцэтгэв. Нийгмийн даатгалын шимтгэл төлөлттэй холбоотой иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирсэн нийт 87 өргөдөл хүсэлтийг үндэслэн төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийсэн. Шалгалтаар 74 аж ахуйн нэгж байгууллагын нийгмийн даатгалын | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шимтгэл төлөлттэй холбоотой илэрсэн төлбөр зөрчилд 38464922.93 төгрөгийн улсын байцаагчийн акт тогтоож, 38464922.93 төгрөгийг барагдуулж, актын биелэлт 100.0%-тай байна. Тайлант хугацаанд аж ахуйн нэгж байгууллагад 23 албан шаардлага хүргүүлж, уулзалтын 213 тэмдэглэл хөтөлж, данс хаах 3 мэдэгдэл өгч, өр авлага барагдуулах 32 гэрээ байгуулж ажилласан байна.<br>Зөрчлийн тухай хуульд заасан үндэслэлээр 7 байгууллагын нягтлан бодогчийг 50 нэгжээр, 1 байгууллагыг 200 нэгжээр торгож, хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн. 2024 онд тогтоогдсон нийт актын биелэлт 81.2 хувьтай байна. Актын барагдуулалтын хугацаа болоогүй 2 актын 13007.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. | |
| 3.2.2. | Хил хамгаалах ерөнхий газартай 2023 оны 02 дугаар сарын 17-ны өдөр байгуулсан 03/НД-22/23 дугаартай хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд зохион байгуулж хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнг нэгтгэж дүгнэх, | Шаард-лагагүй | Хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд зохион байгуулж хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүнг хагас, бүтэн жилээр аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газруудаас гаргуулан авч нэгтгэж дүгнэх, | Хил хамгаалах ерөнхий газартай хамтран ажиллах санамж бичгийг 2023 оны 02 дугаар сарын 17-ны өдөр шинэчлэн байгуулсан. | Холбогдох судалгаа, тооцоо, дүгнэлтэд үндэслэн Хилийн цэргийн анги, тусгай салбартай хамтарсан шалгалт хийж үр дүнг тооцож, цаашид авах арга хэмжээний санал боловсруулж ажиллах | Хил хамгаалах ерөнхий газартай 2023 оны 02 дугаар сарын 17-ны өдөр байгуулсан 03/НД-22/23 дугаартай хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд Хөвсгөл аймаг дахь Хилийн цэргийн 0257-р ангийн 21 албан хаагчийн 31726,1 мянган төгрөгийн цалингийн сангаас 3914.4 мянган төгрөгийн шимтгэлийн акт, 1172.5 мянган төгрөгийн алданги, нийт 5086.9 мянга төгрөгийн актыг 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдөр тогтоосон. Тухайн онд 5086.9 мянган төгрөгийг барагдуулж актын биелэлт 100 хувьтай байна. 2024 оны 10-р сард ирсэн албан бичгийн дагуу хилийн цэргийн 0257-р ангийн нягтлан бодогчтой хамтран цэргийн ар гэрээр ажиллаж байсан 2 даатгуулагчийн 3854.7 мянган | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төгрөгийн цалингийн сангаас 636.0 мянган төгрөгийн шимтгэлийг нөхөн төлүүлэхээр шийдвэрлэж, тайлан мэдээг НДЕГ-т хүргүүлсэн. Актын биелэлт 100 хувьтай байна. | |
| 3.2.3. | Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн 2021-2023 оны орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт шалгалт хийх | | 21 аймаг, 9 дүүргийн хэмжээнд ҮОМШӨ-ний сангийн зарцуулалтад хяналт шалгалт хийж илэрсэн зөрчилд хуулийн дагуу хариуцлага тооцож, үр дүнд хяналт тавьж ажиллах, | - | ҮОМШӨ-ний сангийн бүрдүүлэлт, зарцуулалтыг мэдээллийн нэгдсэн сангийн өгөгдөл болон анхан шатны баримтад тулгуурлан 21 аймаг, 9 дүүргийн хэмжээнд шалгаж, илэрсэн зөрчлийн 80 хүртэл хувийг барагдуулж ажиллах | Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн 2021-2023 оны орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт шалгалт хийгдэж 7 иргэнтэй холбоотой 16,228,865 төгрөгийн тэтгэврийн акт, 4 иргэнтэй холбоотой 1,087,821 төгрөгийн тэтгэмжийн акт, 3 ажил олгогчтой холбоотой 8,926,303 төгрөгийн шимтгэлийн акт, сан хоорондын залруулга хийх 180 иргэнтэй холбоотой 30,189,850 төгрөгийн акт, нийт 56,432,839 төгрөгийн улсын байцаагчийн акт тогтоогдож 36,140,291 төгрөгийг барагдуулж актын биелэлт 64%-тай байна. | 85% |
| 3.2.4. | Нийгмийн хамгааллын салбарын хяналтын чиглэлээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн объектод төлөвлөгөөт шалгалт хийх | | Хяналт шалгалт хийсэн объектын тоогоор , гүйцэтгэлийн хувь, хууль сахин мөрдөлтийн түвшин, илрүүлсэн зөрчил, арилгуулалтын хувь, Улсын байцаагчийн шийдвэрийн биелэлт, Эрсдэлийн түвшин буурсан объектын тоо, хувь | | Их, дунд эрсдэл бүхий аж ахуйн нэгж байгууллагын 80 хүртэл хувийг шалгаж, ирэлсэн зөрчлийн 70-аас доошгүй хувийг барагдуулах | Нийгмийн хамгааллын салбарын хяналтын чиглэлээр Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын хөдөлмөрийн байцаагч нартай хамтран зам тээврийн үйл ажиллагаа явуулдаг Хөвсгөл АЗЗА, Хөвсгөл зам ХХК-д төлөвлөгөөт хяналт шалгалтыг 2024 оны 10 дугаар сарын 05-09-ны өдрүүдэд хийж гүйцэтгэсэн. Шалгалтын танилцуулга болон тоон мэдээг Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлж ажилласан. . | 100% |
| 3.2.5. | Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2019 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн А/50 дугаар тушаалаар | | Нийгмийн даатгалын салбарын "Цахим хяналтын веб програм"- | Цахим хяналт, шалгалтыг тогтмолжуулж, илэрсэн зөрчлийн 86,0 хувийг шалгаж, залруулсан. | Нийгмийн даатгалын салбарын "Цахим хяналтын веб програм"-(http://10.9.0.5/monitor | Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2019 оны А/50 дахь "Заавар батлах тухай" тушаалаар батлагдсан "Цахим хяналт шалгалтын ажлын заавар"-ын хүрээнд 2024 онд Арбулаг, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | баталсан “Цахим хяналт, шалгалтын ажлын заавар”-ын дагуу цахим мэдээлэлд тулгуурлан хийх хяналт, шалгалтыг тогтмолжуулах, | | (http://10.9.0.5/monitoring)-д тулгуурлан хяналт, шалгалтыг сар бүр тогтмол хийж “Цахим хяналт, шалгалтын ажлын заавар”-ын 3.4-т заасан хугацаанд холбогдох газарт хүргүүлнэ. | | ing)-аас тодорхой өгөгдлийн дагуу шүүлт хийж, зөрчилтэй байх магадлалтай мэдээллийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу шалгаж шийдвэрлэсэн байна. | Түнэл, Алаг-эрдэнэ, Шинэ-Идэр, Ханх, Тосонцэнгэл, Хатгал, Их-Уул сумын нийт 859 тэтгэврийн тогтоолт, олголтыг цахим мэдээллийн сантай тулган шалгав. зөрчил дутагдлыг шийдвэрлэж ажилласан. Хяналт шалгалтаар 1 тэтгэвэр авагчтай холбоотой 14453.3 мянган төгрөгийн төлбөр зөрчилд акт тогтоож, төлбөр төлөх гэрээ байгуулж ажиллаж байна. Тайланд хугацаанд 2000.0 сая төгрөгийг барагдуулсан. Актын барагдуулалтын хугацаа болоогүй 1 актын 12453,3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. | |
| 3.2.6 | Дотоодын хяналт, шалгалтын тайланг хагас бүтэн жилээр үнэн зөв гаргаж нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлантай тулган баталгаажуулах, Нийгмийн даатгалын ерөнхий газраас болон хөндлөнгийн хяналт, шалгалтаар илэрсэн төлбөр, зөрчлийн барагдуулалт, шалгалтын мөрөөр зохион байгуулж хэрэгжүүлсэн ажлын үр дүнг тооцож тайлан, мэдээг заасан хугацаанд хүргүүлэх, | | Дотоодын хяналт, шалгалтын хагас жилийн болон жилийн тайланг Нийгмийн даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн дагуу, Нийгмийн даатгалын ерөнхий газраас болон хөндлөнгийн хяналт, шалгалтаар илэрсэн төлбөр, зөрчлийн барагдуулалт, шалгалтын мөрөөр зохион байгуулж хэрэгжүүлсэн ажлын үр дүнг улирал тутамд гаргаж Хяналт, шалгалтын газарт хүргүүлнэ. | Дотоодын хяналт, шалгалтын тайлан хагас бүтэн жилээр 2023 онд хүргүүлсэн. | Шалгалтын үр дүнг хэлтсийн даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж холбогдох шийдвэр гаргуулан актаар тогтоогдсон төлбөрийн 70-аас доошгүй хувийг барагдуулсан байна. | Тэтгэврийн актын үлдэгдэл 2024 оны 12-р сарын 10-ны байдлаар /1218/ 126612.9 мянган төгрөг, НДЕГазраас тавьсан актын үлдэгдэл 27370.4 мянган төгрөг, Тэтгэмжийн актын үлдэгдэл 25430.2 мянган төгрөг, Ажилгүйдлийн тэтгэмжийн актын үлдэгдэл 24504.5 мянган төгрөг, ЭМД-ын үлдэгдэл 1341.7 мянган төгрөг, ҮОМШӨТТТ-ын үлдэгдэл 165.1 мянган төгрөг, бусад авлага 17498.9 мянган төгрөг бүгд 222923.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй /1218/ байна. Өмнөх оны үлдэгдэл 211951.5 мянган төгрөгөөс 36329.1 мянган төгрөгийг, тайлант онд шинээр үүссэн 260469.0 мянган төгрөгийн авлагаас 213167.5 мянган төгрөгийг барагдуулж ажилласан. Нийт 472420.5 мянган төгрөгөөс 249496.6 мянган төгрөгийг барагдуулж, нийт актын биелэлт 81.2 хувьтай байна. 2024 онд тавигдсан тэтгэврийн актын дүн 14453,3 мянган төгрөгөөс 2000.0 мянган төгрөг барагдуулсан. Үлдэгдэл 12453.3 мянган төгрөгийг хуваарийн дагуу төлж байна. Дотоодын хяналт шалгалтын тайланг хагас бүтэн жилээр НДЕГазарт хүргүүлсэн. | 85% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | |

***Дөрөв. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилт.***

Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг судалж, хэрэгжилтийг хангах, төлөвлөх, тайлагнах, хүний нөөцийн бодлого, төлөвлөлтийг оновчтой зохион байгуулах, нийгмийн даатгалын үйлчилгээг хөгжүүлэх замаар байгууллагын тогтвортой хөгжлийг хангах

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.1.1. | Нийгмийн даатгалын салбарын хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай холбоотой гарсан тогтоол, тушаал шийдвэр болон гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ, ажил үйлчилгээний хэрэгжилт, тайлан, дээд байгууллагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хугацаанд нь хүргүүлэх. | | Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоол, зөвлөмж, Засгийн газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилт хангагдсан байна. | 2023 оны жилийн эцсийн байдлаар аймаг, нийслэлийн нийгмийн даатгалын хэлтсүүдээс НДЕГ-аас өгсөн үүрэг даалгавар, тогтоол шийдвэр, чиглэл зөвлөмж, үйл ажиллагааны тайлан, зорилтот жилийн төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэн авч дүгнэхэд нийт салбарын хэмжээнд хэрэгжилт 83,5%-тай хэрэгжсэн байна | Өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь хэрэгжүүлж, биелэлтийг 06 сарын 20, 12 сарын 20-ны дотор НДЕГ-ын Тамгын газарт хүргүүлнэ. | Нийгмийн даатгалын салбарын хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай холбоотой гарсан Засгийн газрын тогтоол 4, ХНХЯ-ны сайдын тушаал 2, албан даалгавар 1, журам 21, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоол 5, НДЕГ-ын тушаал 15, чиглэл 16, зөвлөмж 9, дүрэм 4, заавар 2, аргачлал 3 нийт 82 албан бичгийн хэрэгжилтийг хангаж ажилласан. 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ, ажил үйлчилгээний хэрэгжилт, үүрэг даалгаврын 15 биелэлтийг хугацаанд нь хүргүүлсэн. | 100% |
| 4.1.2. | ААНБ, иргэд, даатгуулагчдаас ирүүлсэн санал, өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэх ажлыг зохион байгуулах, үр дүнг хуулийн хугацаанд тайлагнах. | | Өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шуурхай шийдвэрлэх ажлыг зохион байгуулж, үр дүнг хуулийн хугацаанд тайлагнасан | Иргэд, байгууллагаас ирсэн санал 218 өргөдөл, гомдлыг шийдвэрлэлт 2023 онд 89,1 %-тай хэрэгжсэн байна. | Иргэд, даатгуулагч, ААНБ-аас ирсэн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд бүрэн барагдуулж, мэдээг үнэн бодит гаргаж улирал бүрийн сүүлийн сарын 20-ны дотор НДЕГ-ын Тамгын | Тайлант хугацаанд иргэд, байгууллагаас сайн дурын даатгалын залруулга хийх хүсэлт 118, нийгмийн даатгалын шимтгэл нөхөн төлүүлэх хүсэлт 87, тэтгэвэр дахин хянуулах хүсэлт 44, Маргаан хянан шийдвэрлэх зөвлөлд 98, бусад шалтгаанаар 84 нийт 431 өргөдөл гомдол хүлээн авч хуулийн хугацаанд 418 өргөдөл гомдлыг шийдвэрлэсэн. Хугацаа болоогүй | 98.4% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сургалтад тус газрын дарга, нэгжийн дарга нийт 4 албан тушаалтан суралцаж төгссөн. | |
| 4.1.7. | Газрын албан хаагчид авлига, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх | | Авлигаас урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулсан байна. | Газрын ажилтнуудад авлигын тухай, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтыг зохион байгуулах. | Газрын албан хаагчид авлига, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаарх мэдлэг дээшилж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллана. | Аймгийн Прокурорын газрын зөрчлийн ахлах прокурор С.Батсүх, зөрчлийн прокурор н.Батзолбоо нар 2024 оны 04-р сарын 05-ны өдөр “Зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаанд хяналт тавих” сургалтыг газрын албан хаагчдад танхимаар, сумдын байцаагч нарыг цахимаар хамрууллаа. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Соёмбо танхимд Авлигатай тэмцэх газрын комиссар Н.Амартүвшин Авлигын хэрэг зөрчил, түүнээс урьдчилан сэргийлэх талаар сургалт хийж, тус сургалтад газрын эрх бүхий албан тушаалтнууд хамрагдаж авлига, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлж ажиллаж байна. 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдөр Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан ЭБАТ-ны цахим сургалтад газрын албан хаагчид бүрэн хамрагдсан. Мөн 2024 оны 9, 10-ны өдрүүдэд Хөвсгөл аймагт зохион байгуулагдсан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааг танилцуулах, авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлах сургалтад газрын дарга хамрагдсан. Газрын нийт 49 албан хаагчдад авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтыг дотооддоо 2 удаа зохион байгуулсан. Тус газрын 27 албан хаагч 2023 оны ХАСХОМ-ыг хуулийн хугацаанд мэдүүлсэн. 2024 онд газрын албан хаагчдаас авлига, гэмт хэрэг, зөрчилд холбогдсон албан хаагч | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Мөн газрын Захиргаа, хяналтын хэлтсээс эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор 4 удаагийн зөвлөмжийг газрын нийт 43 албан хаагчдад хүргүүлсэн.<br>Тус газрын дотоод орчныг тохижуулах чиглэлд бүх өрөө тасалгааны хаяг, самбарыг шинэчилж, үйлчилгээний зааланд "Үйлчлүүлэгчийн булан"-г өөрчлөн тохижуулж, иргэдийн ая тухтай байдлыг бий болгох зорилгоор сандал, ширээ, буйдан зэрэг тавилга хэрэгсэл байршуулсан.<br>Нийгмийн даатгалын газрын Сургалт, сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн нь Нийгмийн даатгалын ач холбогдол, хууль, эрх зүйн өөрчлөлтийн талаар аж ахуй нэгж байгууллага, иргэд даатгуулагчдад мэдээ мэдээллийг Podcast хэлбэрээр 2, Live хэлбэрээр 5 удаа, Reel хэлбэрээр 6 удаа хийж нийт хандалтын тоо 13441 хүрсэн байна. Сошиал сурталчилгааны энэхүү төрлийг 2024 онд шинэлэг ажил болгож хүрээг өргөжүүлэн ажиллах төлөвлөгөө гаргаж ажилласан. | |
| 4.1.6. | Нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг дунд хугацаагаар төлөвлөн боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллах. | | Газрын ажилтан албан хаагчдын нийгмийн баталгааг хангасан байна. | Ажилтан, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах дунд хугацааны хөтөлбөр боловсруулан баталж, хэрэгжүүлнэ. | Нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг дунд хугацааны төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган, үр дүнг 06 сарын 20, 12 сарын 20-ны дотор НДЕГ-ын Тамгын газарт тайлагнасан байна. | Төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын дагуу 29 төрийн жинхэнэ албан хаагчид 186245.4 төгрөгийн урамшуулал, Төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгох журмын дагуу 27 албан хаагчид, Нийгмийн даатгалын улсын байцаагчид мэргэшлийн зэрэг олгох журмын дагуу 20 байцаагчид зөвлөх болон тэргүүлэх зэргийн нэмэгдлийг тус тус олгож байна.<br>Удирдлагын академийн Төрийн албаны сургуулийн "Төрийн захиргааны ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үйлчиллээ.<br>Байцаагч ажилтнуудаас хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу 2023 оны 261 баримтыг хадгаламжийн нэгж үүсгэн архивт хүлээн авсан. | |
| 4.1.4. | Батлагдсан орон тоо, төсвийн хүрээнд үйл ажиллагаа явуулах. | | Төрийн албаны тухай хууль тогтоомж, журмын дагуу хүний нөөцийг томилох, чөлөөлөх шийдвэрийг гаргаж байна. | Хууль тогтоомжийн хүрээнд хүний нөөцийг бүрдүүлэх, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл боломжоор хангах. | Орон тоо, төсвийн хүрээнд хүний нөөцийг томилох, чөлөөлөх шийдвэрийг хууль тогтоомжийн дагуу гаргаж НДЕГ-т Тамгын газарт улирал бүр тайлагнасан байна. | НДЕГ-ын даргын 2024 оны А/51 дугаар тушаалын дагуу бүтэц орон тоондоо багтаан 3 хэлтсийн зохион байгуулалтаар 47 байцаагч, 6 үйлчилгээний ажилтан, нийт 54 орон тоотой ажиллахаас тайлант хугацаанд 49 албан хаагч ажиллаж байна. Төрийн албаны сул орон тоог нөхөх зарыг 2024 онд Төмөрбулаг сум-2, Улаан-Уул сум-2, Рэнчинлхүмбэ сум-1, нийт 5 удаа сумын нийгмийн даатгалын байцаагчийн сул орон тоог зарлуулах хүсэлтийг Төрийн албаны салбар зөвлөлд хүргүүлсэн байна. Тариалан сумын нийгмийн даатгалын байцаагчийн сул орон тооны захиалгыг 2023 онд ТАСЗ-д 4 удаа хүргүүлж 2024 оны 01 дүгээр сард салбар зөвлөлийн тогтоолын дагуу Тариалан сумын байцаагчийг томилсон. 2024 онд хүний нөөцтэй холбоотой 48 тушаал шийдвэр гарсан байна. | 100% |
| 4.1.5. | Газрын дотоод ажлыг сайжруулах чиглэлээр тодорхой, шинэлэг ажил зохион байгуулах, тайланг хүргүүлэх | | Ажлын байр /албан тушаал/-ын тодорхойлолтоор заагдсан чиг үүргийг хэрэгжүүлсэн байна. | Газрын ажилтан, албан хаагчдын ажлын байрны чиг үүрэг тодорхой болсон байх. | Газрын дотоод ажлыг сайжруулсан, шинэлэг ажил үйлчилгээ нэвтрүүлсэн талаар тайланг 06 сарын 20, 12 сарын 20-ны дотор НДЕГ-ын Тамгын газарт хүргүүлнэ. | Газрын дотоод ажлыг сайжруулах ажлын хүрээнд нийт албан хаагчдад анхан шатанд иргэдийн баримт материалыг үнэн зөв бүрдүүлэх, үйлчилгээг чирэгдэлгүй хүргэх зорилгоор арга зүйн зөвлөмжийг тухай бүр өгч ажилласан. 2024 онд хуулийн хэрэгжилт, шинэ программ хангамж нэвтэрсэн, журам дүрэм өөрчлөгдсөнтэй холбоотой танхимаар 3 удаа, цахимаар 8 удаа сургалт хийсэн. | 95% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | байна. | | газарт хүргүүлнэ. | хүлээгдэж байгаа 13 өргөдөл байна. Шийдвэрлэлт 96,9 хувьтай. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн дагуу иргэдээс тэтгэвэр тогтоолгох хүсэлт 1310, тэтгэвэр өөрчлөх хүсэлт 344, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн дагуу тэтгэмж тогтоолгох хүсэлт 2786, нийт 4871 өргөдлийг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байна. Үүнээс 16 тэтгэвэр, тэтгэмжийн өргөдөл хуулийн үндэслэл хангахгүй шалтгааны улмаас буцаагдсан. Засгийн газрын "Иргэд олон нийттэй харилцах төвд иргэд даатгуулагчаас 14, НДЕГ-ын "Иргэд олон нийттэй харилцах 311131 утсанд 48, нийт 62 өргөдөл гомдол гаргасан. Өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд бүрэн барагдуулж, шийдвэрлэлт 100%, Нийт өргөдөл, гомдлын шийдвэрлэлт 98,4 хувьтай байна.<br>Хуулийн хугацаа болоогүй хүлээгдэж байгаа 13 өргөдөл, гомдол нь нийт өргөдөл гомдлын 3.0 хувийг эзэлж байна. | |
| 4.1.3. | Нийгмийн даатгалын байгууллагын салбарын хэмжээнд архивын үйлчилгээг сайжруулах, ажил олгогч, иргэд, даатгуулагчид нийгмийн даатгалын үйлчилгээг чирэгдэлгүй, хөнгөн шуурхай үзүүлэх. | | Нийгмийн даатгалын хэлтэс дотооддоо болон хэлтсүүд хооронд шимтгэл төлөлтийн лавлагааг цахимаар солилцох ажлыг зохион байгуулна. | Нийгмийн даатгалын болон архивын үйлчилгээг иргэд, хуулийн этгээд, даатгуулагчдад хөнгөн шуурхай, чирэгдэлгүй үзүүлсэн. 2023 онд 872 архивын лавлагааг хянасан. | Архивын лавлагааг цахимаар солилцох боломжийг бүрдүүлсэн байна. | Газар, хэлтэс хооронд нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагааг цахимаар солилцох ажлыг зохион байгуулж нийт 9 дүүрэг, 6 аймгийн цахим 93 хүсэлтийг хүлээн авч, 93 лавлагаа гаргаж, тус газраас 7 дүүрэг, 8 аймагт лавлагаа авах 45 хүсэлтийг илгээж холбогдох лавлагааг хүлээн авч ажилласан.<br>Нийгмийн даатгалын дэвтэр засвартай, хаяж үрэгдүүлсэн зэрэг шалтгаанаар тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгохтой холбоотой цаасан суурьтай баримтаас 845 лавлагаа, QR кодтой 405 лавлагаа нийт 1250 иргэнд нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагаа олгож | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байхгүй болно. | |
| 4.1.8. | Нийгмийн даатгалын газрын ажлын байрны болон үйлчилгээний стандартын хэрэгжилтийг хханган ажиллах | | НДЕГ-ын 2016.12.07-ны өдрийн "Нийгмийн даатгалын байгууллагын байцаагч (ажилтан)–ийн үйлчлүүлэгчтэй харилцах журам" батлах тухай А/61 дүгээр тушаал, 2019.12.13-ны өдрийн "Нийгмийн даатгалын хэлтэс (тасаг)–ийн ажлын байр, үйлчилгээний орчны стандарт" батлах тухай А/194 дугаар тушаалын хэрэгжилтийг мөрдөж ажилласан байна | - | Нийгмийн даатгалын газрын ажилтан албан хаагчдын харилцаа хандлагыг сайжруулж, ажлын байр, үйлчилгээний орчны стандарт хэрэгжилтийг хханган ажилласан байна. | Нийгмийн даатгалын газрын ажилтан албан хаагчдын харилцаа хандлагыг сайжруулах талаар газрын удирдлагаас 3 удаа, Төрийн албаны ёс зүйн тухай хуулиар 1 удаа сургалт хийсэн.<br>Үйлчилгээний стандартыг хангах зорилгоор газар, хэлтэс сумдын албан хаагч, ажилтнуудыг жигд хувцас өмсөх шаардлагыг тавьж ажилласан. 2024 оны 04-р сард Нийгмийн даатгалын газарт хэрэгжиж буй ажлын байрны стандартад үнэлгээ хийсэн. Нэг цэгийн үйлчилгээний зааланд ажил олгогчийн булан бий болгож, ширээ сандал байршуулсан. Үйлчилгээний орчны стандарт хэрэгжилтийг хангах чиглэлд анхаарч ажилласан. | 93% |
| Нийгмийн даатгалын байгууллагын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх, олон нийт, харилцагч байгууллага салбар хэлтэс, тасгуудад мэдээлэл түгээх, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар байгууллагын тогтвортой хөгжлийг хангах | | | | | | | |
| 4.2.1. | Нийгмийн даатгалын байгууллагын ажилтны мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалт зохион байгуулах; | | Хүний нөөцийг чадавхижуулах чиглэлээр зохион байгуулсан сургалтын тоо, хамруулсан хүний тоо | Албан хаагчдыг мэргэшүүлэх, ур чадварыг дээшлүүлэх 5 удаагийн сургалтад 209 албан хаагчийг хамруулсан. | -Албан хаагчдыг мэргэшүүлэх, ур чадварыг дээшлүүлэх танхимын болон цахим сургалт зохион байгуулна.<br>-Шинэ ажилтныг ажлын байран дээр дадлагажуулах сургалт зохион байгуулж, хөрвөх | Албан хаагчдын мэдлэг ур чадвар, хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор цахимаар болон танхимаар сургалт зохион байгууллаа. Үүнд: НДЕГ-ын шинэ систем (Sicos)-ийн заавар сургалтыг цахимаар 12 удаа, НДГазраас сумдын байцаагч нарт танхимаар 3, цахимаар 5 удаа, Цахим хөгжил, харилцаа холбооны яам, аймгийн ЗДТГ-аас хамтран зохион байгуулсан "Цахимд хэвшье" сургалт 1, | 93% |

<table>
<tr>
<td></td>
<td></td>
<td></td>
<td></td>
<td></td>
<td>чадвар бүхий мэргэжилтэн бэлтгэнэ.</td>
<td>Авлигатай тэмцэх газар, Аймгийн Прокурорын газраас хууль эрх зүйн 3, нийт 15 сэдвийн хүрээнд 24 удаагийн сургалтад 268 албан хаагчид /давхардсан тоогоор/ хамрагдсан.<br>
<table>
<tr><th>№</th><th>Зохион байгуулсан газар хэлтэс</th><th>Сургалтын тоо</th><th>Байцаагчийн тоо</th></tr>
<tr><td>1</td><td>НДЕГазар</td><td>8</td><td>156</td></tr>
<tr><td>2</td><td>НДГ</td><td>9</td><td>72</td></tr>
<tr><td>3</td><td>Аймаг болон бусад байгууллага</td><td>7</td><td>40</td></tr>
<tr><td></td><td>Нийт</td><td>24</td><td>268</td></tr>
</table>
Сумдын байцаагч нарыг НД-ын шинэ программд дадлагажуулах танхимын сургалтыг 3 удаа нийт 44 байцаагчид хийж, дадлагажуулах сургалтын үр дүнд бүх сумдын байцаагч нар хариуцсан сумын даатгуулагчдын сайн дурын даатгалын гэрээг сум хариуцсан байцаагч нарын Sicos эрхээр орж байгуулан нийт 23 сумын хувиараа хөдөлмөр эрхлэгч 381 иргэн, ХБХА эх/эцэг-ийн 63 иргэн, 0-3 насны хүүхэдтэй 750 эхийн, малчнаар 3847 нийт 5041 сайн дурын даатгуулагчийн гэрээг байгуулж ажилласан.</td>
<td></td>
</tr>
<tr>
<td>4.2.2.</td>
<td>Ажил олгогч, иргэд, малчид, албан бус хөдөлмөр эрхлэгчид, оюутан сурагчдад нийгмийн даатгалын ач холбогдол, нийгмийн даатгалын тухай хуулиудад орсон өөрчлөлт, сайн дурын даатгалын чиглэлээр сургалт зохион</td>
<td></td>
<td>Нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх чиглэлээр зохион байгуулсан сургалтын тоо, хамрагдсан хүний тоо</td>
<td>Ажил олгогч, даатгуулагч 38, малчин, албан бус хөдөлмөр эрхлэгчид чиглэсэн 6 удаагийн сургалтад 415 иргэд, даатгуулагчийг хамруулсан.</td>
<td>Сургалт зохион байгуулж, иргэд, даатгуулагчдын нийгмийн даатгалын талаарх мэдлэг, мэдээлэл дээшилж, хамралт нэмэгдсэн байна.</td>
<td>Ажил олгогч, даатгуулагч, малчин, албан бус хөдөлмөр эрхлэгчид, оюутан сурагчдад чиглэсэн нийгмийн даатгалын ач холбогдол, нийгмийн даатгалын тухай хуулиудад орсон өөрчлөлт, чиглэлээр 426 удаагийн сургалтаар нийт 17251 иргэд даатгуулагчдыг хамруулсан байна. Үүнээс:<br>Аймгийн хэмжээнд явуулын үйлчилгээг-13094 иргэнд, өдөрлөг арга хэмжээг-</td>
<td>100%</td>
</tr>
</table>

<table>
<tr>
<td></td>
<td>байгуулах;</td>
<td></td>
<td></td>
<td></td>
<td></td>
<td>4157 иргэнд, ЕБС-ын төгсөх ангийн-787 сурагчдад, иргэд нийтийн хурал болон бусад хэлбэрээр дамжуулан НД-ын мэдээ мэдээлэл, төрийн үйлчилгээг хүргэж ажиллаа. Иргэд, даатгуулагчдын мэдлэг, мэдээлэл дээшилсэн.
<table>
<tr><th>№</th><th>Сургалт хийсэн чиглэл</th><th>Сургалтын тоо</th><th>Хамрагдсан даатгуулагчийн нийт тоо</th></tr>
<tr><td>1</td><td>Ажил олгогч, албан байгууллага</td><td>153</td><td>6885</td></tr>
<tr><td>2</td><td>Баг, хороод /тэтгэвэр тогтоолгох эрх үүсч буй иргэд/</td><td>137</td><td>736</td></tr>
<tr><td>3</td><td>Оюутан, сурагч</td><td>13</td><td>787</td></tr>
<tr><td>4</td><td>малчид</td><td>125</td><td>8843</td></tr>
<tr><td></td><td>Нийт</td><td>428</td><td>17251</td></tr>
</table>
</td>
<td></td>
</tr>
<tr>
<td>4.2.3.</td>
<td>Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэл, ач холбогдол, нийгмийн даатгалын үйлчилгээ, үйл ажиллагаа, цаг үеийн мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээгээр өргөнөөр сурталчлах;</td>
<td></td>
<td>Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэл, ач холбогдол, нийгмийн даатгалын үйлчилгээ, үйл ажиллагаа, цаг үеийн мэдээллийг сурталчлах зорилгоор орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр зохион байгуулсан арга хэмжээний тоо, төрөл, Нийгмийн сүлжээний хуудас</td>
<td>Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, нийгмийн сүлжээгээр сурталчилгаа хийсэн тоо-137, мэдээллийн төрөл</td>
<td>Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэл, ач холбогдол, нийгмийн даатгалын үйлчилгээ, үйл ажиллагаа, цаг үеийн мэдээллийг орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээ болон бусад хэлбэрээр олон нийтэд ойлгомжтой, шуурхай хүргэсэн байна.<br>ХНХЯ болон НДЕГ-аас бэлтгэсэн мэдээллийг бүх албан хаагчдаар цааш түгээлгэж, олон нийтэд хүргэх ажлыг зохион</td>
<td>НДГ-ын үйл ажиллагаа, цаг үеийн мэдээ, мэдээллийг “Нийгмийн даатгалын газар” пэйж хуудсанд 95 удаа байршуулж, 51299 хүний хандалт авсан үр дүнтэй байна. Хөвсгөл аймгийн “ANZAAR” хувийн сайтаар дамжуулж (ТВ, радио, сонин, сэтгүүл зэрэг) 14 мэдээ мэдээллийг олон нийтэд түгээж, 504 хандалт авсан.<br>НДГ-ын пэйж хуудсаар 28 удаагийн постер, 6 удаагийн лайв, 4 удаагийн видео, 1 удаагийн рийлийг бэлтгэн хийж албан хаагчдаар facebook хуудсаар түгээлгэн 51466 хандалтыг авсан байна.<br>НДЕГ-ын бэлтгэж нийтэлсэн болон аймгийн НДГ-аас нийтэлсэн нийт 134 постер болон цаг үеийн мэдээ мэдээллийг аймгийн 24 сумын байцаагч, мэргэжилтнүүд харьяа сумын ЗДТГ-ын пэйж хуудас, сумдын</td>
<td>100%</td>
</tr>
</table>

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | (фэйсбүүк)-д байршуулсан мэдээллийн тоо, хандалтын тоо. Бэлтгэсэн нэвтрүүлэг, видео шторк, контент, цахим хичээл, постерын тоо. Иргэд, даатгуулагчид, ажил олгогчид, зорилтот бүлгүүд буюу хувиараа хөдөлмөр эрхлэгчид, малчдад чиглэсэн сурталчилгааны тоо, төрөл зохион байгуулсан арга хэмжээний тоо, төрөл | | байгуулсан байна. | зарын нэгдсэн групп, багийн иргэдийн нэгдсэн группт тухай бүр түгээж ажилласан. Өмнөх 6100 дагагчтай "Хөвсгөл аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс" фэйсбүүк пэйж хуудас нь админы нууц үгийг мэдэхгүй шалтгааны улмаас шинэ админ нэмэх, пэйж хуудасны нэрийг өөрчлөх боломжгүй болсон тул цаашид ашиглахгүй байх шийдвэр удирдлагын түвшинд гаргаж шинээр "**Хөвсгөл аймгийн Нийгмийн даатгалын газар**" пэйж хуудсыг нээн ажиллуулж 1.5 мянган дагагчтай болсон байна. | |
| Нийгмийн даатгалын үйлчилгээг мэдээллийн технологийн үйл ажиллагаагаар дэмжих, мэдээллийн сан бүрдүүлэлт, хадгалалт хамгаалалт, гадаад, дотоод мэдээллийн урсгалын нэгдсэн хяналттай тогтолцоог төлөвшүүлэх, хөгжүүлэх | | | | | | | |
| 4.4.1. | Мэдээллийн сангийн бүрдүүлэлтийг сайжруулж, ажил олгогчоос ирүүлэх мэдээллийг бүрэн гүйцэд бүрдүүлсэн байх | | Ажил олгогчийн үндсэн мэдээллийг бүрэн гүйцэд бүрдүүлсэн байх | Ажил олгогчийн үндсэн мэдээллийн бүрдүүлэлт 99.94% байсан. | Ажил олгогчийн ЭЗҮАСА, татварын бүртгэлийн дугаарыг бүрэн бүрдүүлсэн байна. | Шинээр 146 ажил олгогчийн 253 албан журмын даатгуулагчийг нийгмийн даатгалд шимтгэл төлөгчөөр хамруулж даатгуулагчийн мэдээллийг шинэ системд үнэн зөв бүртгэсэн. НДЕГазрын даргын 2023 оны даатгуулагчийн төрлийн код шинээр батлах тухай А/43 дугаарын тушаалын хэрэгжилтийг ханган аймгийн хэмжээнд 10 аж ахуйн нэгж байгууллагын 7 албан журмын даатгуулагчийн төрлийн кодыг өөрчилж, хаягийн мэдээлэл байхгүй 5 даатгуулагчийн мэдээллийг оруулж, 3 | 100% |
| | | | Ажил олгогчийн НДШ-ийн тайланд ирүүлэх даатгуулагчийн мэдээллийг бүрэн, зөв бүрдүүлсэн байх | | - Даатгуулагчийн үндсэн мэдээллийг бүрэн, зөв хүлээн авсан байна.<br>- Даатгуулагчийн төрлийг бүрэн, зөв хүлээн авсан байна.<br>- Даатгуулагчийн улсын кодыг бүрэн, зөв хүлээн авсан | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байна.<br>- Даатгуулагчийн ажил мэргэжлийн ангиллыг бүрэн, зөв хүлээн авсан байна. | даатгуулагчийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг буруу оруулсныг засварласан. | |
| | | | Ажил олгогчоос цахимаар ирүүлэх тушаалын бүртгэлийг бүрэн гүйцэд шаардаж авсан байх | | Ажил олгогчоос цахимаар ирүүлэх тушаалын бүртгэлийг бүрэн, зөв гүйцэд шаардаж авсан байна. | | |
| 4.4.2. | Албан журмын болон сайн дурын даатгуулагчийн ногдуулалтын мэдээллийг үнэн зөв бүртгэсэн байх | | Албан журмын болон сайн дурын даатгалыг нэг даатгуулагч дээр нэг сар дээр давхардуулан бүртгэхгүй байх | Ажил олгогчийн үндсэн мэдээллийн бүрдүүлэлт 99.94% байсан. | Албан журмын болон сайн дурын даатгалыг нэг даатгуулагч дээр нэг сар дээр давхардуулан бүртгэхгүй байна. | 2024 онд шинэ мэдээллийн системд 1302 аж ахуйн нэгж байгууллагын 17189 даатгуулагчийн мэдээлэл шимтгэлийн тайланг хүлээн авч баталгаажуулсан. Сайн дурын даатгуулагч 10999 байгаагаас ХХЭ-3024, 0-3 насны хүүхдээ асарч байгаа эх-1378, малчин-6427, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч буй эх, эцэг-170 гэрээг байгуулж, ногдуулалтын мэдээллийг үнэн зөв бүртгэсэн. | 100% |
| | | | Сайн дурын даатгалыг нэг даатгуулагч дээр нэг сар дээр давхардуулан бүртгэхгүй байх | | Сайн дурын даатгалыг нэг даатгуулагч дээр нэг сар дээр давхардуулан бүртгэхгүй байна. | | |
| | | | Сайн дурын даатгуулагчийн ногдуулалтыг төлөлтөөс хэтрүүлж хийхгүй байх | | Сайн дурын даатгуулагчийн ногдуулалтыг төлөлтөөс хэтрүүлж хийхгүй байна. | | |
| 4.4.3. | Мэдээллийн технологийн ашиглалтыг сайжруулах | | Програм хангамжуудыг зөв зохистой ашиглаж, аюулгүй байдлыг хангах | | Програм хангамжуудын эрхийн тохиргоог зөв хийх, байцаагч ажилтнууд програм хангамжуудыг зөв зохистой ашиглаж, аюулгүй байдлыг хангаж ажилласан байна. | 2024 онд Нийгмийн даатгалын үйлчилгээнд шинэ программ нэвтрүүлж системийн шинэчлэл хийгдсэн. Үүнтэй холбогдуулан мэдээллийн технологи хариуцсан мэргэжилтнүүдэд МТТ-өөс эрхийн тохиргоо хийх admin эрхийг олгосны дагуу газрын болон сумын 41 байцаагчид Sicos программд нэвтрэх эрхийн тохиргоог албан үүргийнх нь | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | МТТ-өөс хүргүүлсэн албан бичгийн хариу, судалгааг цаг хугацаанд нь ирүүлэх, бусад үүрэг болгосон ажлыг хэрэгжүүлсэн байх | | МТТ-өөс зохион байгуулсан ажлын гүйцэтгэл, албан бичгийн хариу, судалгааг цаг хугацаанд нь үнэн зөв бүрэн ирүүлсэн байна. | хүрээнд тохируулж, хүн тус бүрийн программд нэвтрэх нэр, нууц үгийг албаны и-мэйлээр нь илгээж баталгаажуулсан. Байцаагч нар программ хангамжийг зөв зохистой ашиглаж, аюулгүй байдлыг хангахтай холбогдуулан газрын 21 албан хаагчдыг арга зүйгээр хангаж ажилласан.<br>IT Zone, МТТ-өөс зохион байгуулсан Sicos программын зааварчилгаатай холбоотой системийн ерөнхий заавар 1, тэтгэврийн даатгалын талаар 3, тэтгэмжийн даатгалын талаар 4, ҮОМШӨ-ний Сэргээн засах сувиллын зардлын талаар 2, сайн дурын даатгалын талаар 2, албан журмын даатгалын талаар 3, санхүү бүртгэлийн чиглэлээр 7, ажил олгогчийн тайлангийн системийн талаар 3, даатгуулагчид зориулсан вэб системийн талаар 1, зөрчлийн системийн талаар 2 нийт 28 заавар чиглэлийг хэрэгжүүлж, албан хаагчдад тухай бүр мэдээлж ажилласан. | |

## Тав. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 5.1 | Монгол бичгээр бичих арга зүйд суралцах | Монгол бичгийн мэдлэг дээшилсэн байна. | | Хос бичгээр албан бичиг, мэдээ тайлан боловсруулах чадварт суралцсан байна | Монгол хэл бичгийн боловсролыг дээшлүүлэх, хос бичгээр тайлан мэдээ боловсруулах чадварт бие даан суралцаж байна. | 2024.01.02<br>2024.06.01 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 5.2 | Төрийн албаны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-д заасан богино болон дунд хугацааны сургалтад хамрагдсан байх | Сургалтад хамрагдсан байна | | Сургалтад бүрэн хамрагдаж, мэдлэг эзэмшсэн. | 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс 2024 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн хооронд Төрийн захиргааны ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж 9 багц хичээлийг судалж төгссөн. | 2024.03.15 2024.06.25 | 100% |
| 5.3 | Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсээс зохион байгуулж буй сургалтад хамрагдах | Сургалтад хамрагдсан байна | | | 2024 оны 01 сарын 09-ны өдөр Авлигатай тэмцэх газрын комиссар Н.Амартүвшин “Авлигын хэрэг зөрчил, түүнээс урьдчилан сэргийлэх нь” сургалтыг аймгийн Засаг даргын Тамгын газрын “Соёмбо” танхимд зохион байгуулж, нийт ажилтан албан хаагчдын хамт сургалтад хамрагдсан. | 2024.01.09 | 100% |
| 5.4 | Нийгмийн даатгалын багц хууль, холбогдох дүрэм журам, бусад хууль тогтоомжуудыг уншиж судлах | Хууль тогтоомжийг бүрэн судалсан байна | | Хууль эрх зүйн мэдлэг нэмэгдсэн | Төрийн албаны тухай хууль, Нийгмийн даатгалын багц хууль, бусад холбогдох хууль тогтоомжийг уншиж судалсан. Нийгмийн даатгалын салбарын хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай холбоотой гарсан Засгийн газрын тогтоол 4, ХНХЯ-ны сайдын тушаал 2, албан даалгавар 1, журам 21, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоол 5, НДЕГ-ын тушаал 15, чиглэл 16, зөвлөмж 9, дүрэм 4, заавар 2, аргачлал 3 нийт 82 албан бичгийг уншиж судалж, хэрэгжилтийг хангаж ажилласан. | 2024.01.01 2024.12.09 | 100% |